

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2014.03.12

2013 онд Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулалтынхаа бүтцэд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч, нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг, ажлын уялдаа холбоог сайжруулах, албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох гол зорилго тавин ажиллаж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлж ажиллалаа.

Нэг. Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд үзүүлсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө

Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 70 удаа хуралдаж, чуулганы бэлтгэл хангах, хуралдаан зохион байгуулах ажлыг Тамгын газар хариуцан гүйцэтгэлээ.

Улсын Их Хурлын Байнгын хороодын 209, дэд хороодын 12 удаагийн хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж, Байнгын хорооны хуралдааны дарааллыг бэлтгэж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, 309 хууль, 77 тогтоолын төсөл, 21 хяналт шалгалтын тайлан, Байнгын хорооны 20 төлөвлөгөө, түүний биелэлтийг хэлэлцэж, Байнгын хорооны 96 тогтоолыг баталж, хэлэлцэх эсэхийн 141, анхны хэлэлцүүлгийн 103 санал, дүгнэлт, Байнгын хорооны 53 танилцуулга, 1326 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан чиг үүргийнхээ дагуу нийт 139 хууль, Улсын Их Хурлын 69 тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэн, нэгдсэн хуралдаанаар оруулж, бие даасан хууль 27, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 119, хууль хүчингүй болсонд тооцох тухай 13 хууль, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 4 хууль, Улсын Их Хурлын 69 тогтоолыг тус тус батлуулж, эцсийн найруулгыг хийж, ёсчлуулсан байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Өргөдлийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны 17 удаагийн хэлэлцүүлэг, ярилцлагыг зохион байгуулж, иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудын төлөөллийг өргөнөөр оролцуулан санал авч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа.

Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хорооны тогтоолоор 73 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, 320 удаа хуралдаж, хуулийн төсөл болон

хяналт шалгалтын ажлын дүнгийн талаар санал, дүгнэлт бэлтгэж, Байнгын хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, холбогдох бичиг баримтыг боловсруулах ажлыг хариуцан гүйцэтгэв.

Баталсан хууль тогтоомжуудыг олон нийтэд сурталчлах чиглэлээр 90 гаруй уулзалт, ярилцлага, семинарыг нийслэл, орон нутагт зохион байгуулсны зэрэгцээ хавар, намрын чуулганаар баталсан 51 хууль, тогтоолын танилцуулгыг бэлтгэн ном, CD болгон иргэдэд тарааж, Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлээ.

Хууль санаачлагчийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 80 хууль, 22 тогтоолын бүрдлийг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн дагуу хянаж, Тамгын газрын удирдлагад танилцуулсан бөгөөд 11 хууль, тогтоолыг хуульд заасан шаардлага хангуулахаар хууль санаачлагчид нь албан бичгээр буцаасан.

Шинээр баталсан 139 хууль, Улсын Их Хурлын 76 тогтоолын эцсийн найруулгыг хянаж, тухайн хууль, тогтоолын агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх зэрэг хууль зүйн техникийн шинжтэй засварыг хийсэн байна.

Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын 14 төсөл, Байнгын хороодын захиалгаар 4 төсөл /Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай/ -д экспертийн 18 зөвлөмж гаргаж, хуулийн зөрчил, эрх зүйн хийдэл, давхардлыг арилгах, зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбогдсон 74 санал гаргаж, холбогдох Байнгын хорооны болон ажлын хэсгийн хуралдаанд танилцуулан төсөлд тусгуулав.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцох Улсын Их Хурлын гишүүний тайлбарын 4 төсөл боловсруулж, хуулийн заалтыг хэрэглэх талаар 2 тайлбар гаргасан.

Дотоод сүлжээ болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудсанд шинээр 201 хууль, 65 тогтоолыг файлаар оруулан өөрчлөлт, хөдөлгөөнийг хийж, Тамгын газрын хууль тогтоомжийн санд Ерөнхийлөгчийн 192 зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 420 тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 4 шийдвэрийг тус тус шинээр нэмж оруулан, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 96 дугаарыг хүлээн авч хяналтын хувь бүрдүүлж, 109 удаа хууль тогтоомжийн лавлагаа гаргаж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд хүргүүлэв.

Экспертийн болон Байнгын хороодын ажлын албаны зөвлөхүүд Улсын Их Хурлын гишүүдийн хүсэлтээр 22 удаа хууль, тогтоолын төсөл боловсруулах, төсөл боловсруулахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын ажил, үүргийн хуваарийг боловсронгуй, тодорхой болгох зорилгоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргах журам, загварын маягт, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хянах журам, Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тусгах болон найруулгын засварын тэмдэглэгээ хийх заавар, хуулийн төсөл дээр ажилтнууд тус бүр ямар үүрэгтэй ажиллах тухай журам, Байнгын хорооны хуралдааны дарааллын загвар зэрэг баримт бичгүүдийг шинээр боловсруулан мөрдүүлж байна.

Хянан шалгах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд:

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор хяналт шалгалтын чиглэлээр нийт 13 ажлын хэсэг байгуулагдан ажилласан ба Тамгын газар эдгээр ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Ажлын хэсгүүдэд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 92 гишүүн оролцож 47 яам, агентлагийн үйл ажиллагаа, 40 гаруй хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, Архангай, Говь-Алтай, Булган, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв, Дархан-Уул аймгуудад ажиллаж, хянан шалгах үйл ажиллагаанд оролцов.

Хугацаа	Байгуулагдсан ажлын хэсгийн тоо	
	танилцах	хянан шалгах
Хаврын чуулганы хугацаанд	2	6
Намрын чуулганы хугацаанд	3	2

Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 39 гишүүн 150 асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдэд 27 удаа асуулга тавьсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан 11 асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар сонсох ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайд улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдлын талаар чуулганы хуралдаанд 15 удаа мэдээлэл хийж, Тамгын газар холбогдох хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангалаа. Мэдээллийн цагаар давхардсан тоогоор 134 гишүүн 405 асуулт тавьж, хариулт авсан байна.

Засгийн газрын гишүүдийн 31 тайлан, мэдээллийг сонсож, давхардсан тоогоор 238 гишүүн асуулт асууж, 475 асуултад хариулт авсан байна.

Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газар өгөгдсөн үүрэгтэй холбоотой заалтыг Тамгын газар хяналт бүртгэлдээ авч хэрэгжилтийг хангуулах талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай байнга харилцан холбоотой ажиллаж байна. Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгөгдсөн 50 тогтоолын 267 заалтаас 2 тогтоолын 9 заалт хэрэгжиж, 47 тогтоолын

256 заалт хэрэгжих шатанд, 1 тогтоолын 2 заалт хэрэгжээгүй байна. Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг болгосон 50 тогтоолын 323 заалтаас хэрэгжсэн 19 тогтоолын 65 заалт, хэрэгжих шатанд 41 тогтоолын 159 заалт, хэрэгжээгүй 21 тогтоолын 21 заалт байна.

2013 оны байдлаар давхардсан тоогоор Улсын Их Хурлын гишүүдээс 210 байгууллагад хариу ирүүлэхийг хүссэн хугацаатай 1637 албан бичиг явуулснаас 1337 албан бичигт шийдвэрлэгдсэн тухай хариу ирүүлж, 300 албан бичгийн хариу шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. Улсын Их Хурлын гишүүдээс тодорхой хариу ирүүлэх хугацаа заан явуулсан албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих шинэ маягт боловсруулан, мэдээг улирал тутам гишүүд, яамдаар төрөлжүүлэн гаргаж, дотоод сүлжээнд байршуулж байна.

Тамгын газрын Төсвийн шинжилгээний хэсэг 2013 онд боловсон хүчний хувьд бүрдэж, Засгийн газраас өргөн барьсан төсвийн холбогдох хууль тогтоомжийн төсөлд харьцуулсан судалгаа, шинжилгээ хийж санал дүгнэлтийг УИХ-ын нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт оруулах бэлтгэл ажлыг зохион байгууллаа.

Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангилал, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргаж, 2005-2012 онтой зэрэгцүүлсэн болон 2012 оны батлагдсан төсөвтэй харьцуулж төсвийн хэтрэлт, хэмнэлтийн судалгааг гаргаж ажиллалаа. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2012 оны төсвийн гүйцэтгэл түүнд тулгуурлан харьяа салбаруудын үйл ажиллагааны үр дүн, хүрсэн түвшин, ололт алдаа дутагдлыг эдийн засгийн ангилал, зардлын зүйл тус бүрээр сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулсан судалгаа, шинжилгээ хийж дүгнэлтийг Байнгын хороодод хүргүүлсэн.

Засгийн газраас өргөн барьсан 2013 оны төсвийн тодотгол, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай зэрэг хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт төсвийн зардлын талаар харьцуулсан дүн шинжилгээ хийж хүргүүллээ. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулийн зардал, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойрогт явагдах дахин санал хураалтын зардал болон 5 хуулийн төсөлд төсөвт үзүүлэх ачаалал, зардлын талаар шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж хүргүүлэв.

Хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд:

Тамгын газар нь Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд хороодын хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэлийг цаг тухайд нь гаргаж албажуулахад анхаарч ажиллалаа. Тайлант хугацаанд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 70, Байнгын хороодын 209, дэд хороодын 12 удаагийн хуралдааны бэлтгэлийг хангаж ажилласан байна.

Нэгдсэн хуралдаан:

№	Хугацаа	Хуралдсан тоо	Хуралдсан цаг
1	2012 оны намрын ээлжит чуулган /2012.12.31-2013.02.08/	12	51.55'
2	2013 оны хаврын ээлжит чуулган /2013.04.05-2013.07.10/	26	87.38'
3	2013 оны намрын ээлжит бус /2013.09.16-2013.09.27/	5	10.43'
4	2013 оны намрын ээлжит чуулган /2013.10.01-2013.12.31/	27	100.04'

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар 573 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 4476 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг соронзон хальснаас бичиж буулган, хавсралт материалын хамт нийт 9951 хуудас баримт материалыг архивт шилжүүллээ.

Байнгын хороодын хуралдаан:

№	Байнгын хороодын нэр	Нийт хуралдааны тоо
1	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	31
2	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	22
3	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	21
4	Төрийн байгуулалтын байнгын хороо	25
5	Төсвийн байнгын хороо	35
6	Хууль зүйн байнгын хороо	33
7	Эдийн засгийн байнгын хороо	38
8	Өргөдлийн байнгын хороо	4
	Нийт	209

Байнгын хорооны хуралдааны явцын талаар 774 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 5140 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг соронзон хальснаас бичиж буулган, нийт 5995 хуудас баримт материал, мөн ажлын хэсгийн 36 хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг соронзон хальснаас буулган холбогдох Байнгын хороодын ажлын албанд хүлээлгэн өгч, зохих журмын дагуу цахим хуудсанд байршууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааны нийт 877 цаг 56 минутын бичлэгийг /MP3/ файлд хөрвүүлж, DVD-д хуулан зохих журмын дагуу архивт шилжүүлсэн.

Тамгын газар хэлэлцэж байгаа асуудлын онцлогийг харгалзан төсөл, тодорхой асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх “Хуралдаан удирдах дараалал” 80-ыг бэлтгэн, нэгдсэн хуралдааны үйл ажиллагааг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу явуулах ажлыг зохион байгуулав.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн 32 удаагийн хуралдааны товыг зөвлөлийн гишүүдэд хүргэн, хуралдааны тэмдэглэлийг бичиж албажууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны ирцийг бүрдүүлэх, Улсын Их Хурлын гишүүдэд мэдээ, мэдээлэл, холбогдох зарыг шуурхай хүргэх үүднээс Мобиком ХХК-тай “Web2Sms” үйлчилгээний гэрээ байгуулсны дагуу Улсын Их Хурлын гишүүдэд 575 удаа холбогдох мэдээ, мэдээллийг мессежээр шуурхай хүргэсэн.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн хууль, тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлт, танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёолол, эцсийн найруулга болон бусад материалыг 264 удаа Улсын Их Хурлын гишүүдэд шуурхай хүргэх ажлыг гүйцэтгэв.

Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаагаар хангах ажлын хүрээнд:

Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаагаар хангах үйлчилгээг 2013 оноос Судалгааны алба, Номын сан, Архивын бүтцээр дамжуулан хүргэж эхэллээ.

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын гишүүдийн чуулганаар хэлэлцсэн асуудлууд болон тэдний санаачлан боловсруулсан хуулийн төсөлтэй холбогдох судалгаа, мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллав. Өнгөрсөн онуудтай харьцуулахад 2013 онд Тамгын газраас үзүүлсэн судалгаа, мэдээллийн үйлчилгээ нэмэгдсэн дүнтэй байна. Өмнөх онууд/2009-2012/-д жилд дунджаар 67 судалгааны ажил гүйцэтгэж байсан бол 2013 онд 83 судалгааны ажил гүйцэтгэн хүргүүлээ. Үүнд:

№	Судалгааны төрөл	2013 онд
1.	Бодлогын судалгаа, дүн шинжилгээ	7
2.	Харьцуулсан судалгаа	61
3.	Мэдээлэл лавлагаа, тойм судалгаа	15
4.	Бүгд	83

Судалгааны төрлөөр нь авч үзвэл, сүүлийн жилүүдэд бусад орнуудын туршлага, эрх зүйн орчны харьцуулсан судалгаа хийлгэх захиалга нэмэгдэх хандлагатай байна. Бодлогын судалгаа болон суурь шинжтэй томоохон судалгааны ажлуудыг гадны байгууллага, судлаачдаар гүйцэтгүүлэхээр тооцсон бөгөөд Тамгын газрын бүтэц, орон тоог 2013 оны эхээр баталсан тул 2013 оны төсөвт холбогдох зардал тусгагдаагүй тул энэ ажлыг 2014 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Судалгааны захиалга ирүүлж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх онууд /2009-2012/-д жилд дунджаар 38 гишүүнээс захиалга хүлээн авч байсан бол 2013 онд давхардсан тоогоор нийт 70 гишүүнээс судалгааны захиалга хүлээн авч гүйцэтгэсэн байна. Үүнд:

№	Захиалга	2012 онд	2013 онд	Нийт
---	----------	----------	----------	------

1	Гишүүдийн захиалгаар	35	70	224
2	Байнгын хороодын захиалгаар	9	10	34
3	Тамгын газрын захиалгаар	9	3	28
4	Судалгаа, шинжилгээний хэлтсийн санаачилгаар	8	-	58
5	Бүгд	61	83	344

2013 онд нийт судалгааны 62,6% /52/ нь Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн асуудалд, 37,4% /31/ нь Улсын Их Хурлын гишүүдийн санаачлан боловсруулсан хуулийн төсөл болон бусад асуудалд хамаарч байна.

Улсын Их Хурлын гишүүд болон олон нийтийг мэдээллээр хангах хүрээнд Улсын Их Хурлын 2012 оны намар, 2013 оны хаврын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулга, “Судалгааны эмхэтгэл” -ийн 14, 15 дугаар ботиудыг тус тус эмхэтгэн гаргаж, судалгааны тайлангуудыг тухай бүр мэдээллийн цахим хуудсанд байршуулж, тайланг брошюр хэлбэрээр захиалагчид хүргүүлж ажиллалаа.

2013 онд Улсын Их Хурал, Тамгын газрын ажлын хэрэгцээнд 6.3 сая төгрөгийн, 283 ширхэг ном худалдан авч фондоо баяжууллаа. БНТУ-ын тусламжаар Номын санд өгсөн робот скайнерыг ашиглан “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1991-2011 оны бүх дугаар, Улсын Их Хурлын чуулганы 12 боть танилцуулга, Монгол Улсын хууль тогтоомжийн 16 боть эмхэтгэл болон бусад 350 гаруй ном, сэтгүүл, гарын авлагыг цахим хэлбэрт хөрвүүлж мэдээллийн сан үүсгэв. Тайлант хугацаанд Номын сан нийт 1128 уншигчдад үйлчилгээ үзүүлсэн ба эдгээрийн 98,2 % нь Улсын Их Хурлын гишүүд, тэдгээрийн зөвлөх, туслах, Тамгын газрын ажилтнууд байна. Үүнд:

Уншигчдын ангилал	2012 он	2013 он
УИХ-ын гишүүд, тэдгээрийн зөвлөх, туслах, Тамгын газрын ажилтнууд	1271	1108
Бусад уншигчид	72	20
Бүгд	1343	1128

2013 оноос эхлэн Номын сангийн фондод тулгуурлан Улсын Их Хурлын гишүүдийн захиалгаар сэдэвчилсэн мэдээлэл, лавлагаа гаргаж өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх үйлчилгээ үзүүлж байна.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын 2012, 2013 оны архивын баримт материал, Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороодын хуралдааны дуу, дүрс бичлэгүүдийг холбогдох журмын дагуу Архивт хүлээн авч бүрдүүлэлт хийв. Үүнд:

Он	Архивын нэгж болгон хүлээн авсан баримтын тоо	УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнуудад		Байгууллага, иргэдэд олгосон хуулбар	
		Хүний тоо	Хавтас	Иргэд, байгууллагын тоо	Хуудасны тоо
2012	618 хавтас	512	1713	61	2709

2013	629 хавтас	513	1189	153	12462
------	------------	-----	------	-----	-------

БНСУ-ын тусламжтай хэрэгжүүлсэн цахим архивын төслийн хүрээнд Улсын Их Хурлын 2004-2007, 2012, 2013 оны баримт материалуудыг скайнердаж, цахим мэдээллийн сан бүрдүүлээ.

Хоёр. Улсын Их Хурлыг сурталчлах, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд үзүүлсэн туслалцаа

Улсын Их Хурлын 2012 оны намрын, 2013 оны хаврын ээлжит чуулган, 2013 оны ээлжит бус чуулган, 2013 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдаан, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүдийн хөдөө орон нутаг, тойрогтоо ажилласан томилолт, Улсын Их Хурлын гадаад хамтын ажиллагаа болон Тамгын газрын үйл ажиллагаа, цаг үеийн асуудлаар нийт 1000 гаруй мэдээ, дүрстэй мэдээлэл бэлтгэж, www.parliament.mn, open.parliament.mn цахим хуудсанд байршуулав. Сайт руу хандсан иргэдийн тоо 98000 хүрсэн байна.

Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы нээлт, хаалтын үйл ажиллагааг МҮОНРТ-ийн 2 дугаар суваг, Юнивишн, Сансар кабелийн суваг, ТМ телевиз болон www.parliament.mn цахим сайтаар онлайнаар шууд дамжуулан олон нийтэд хүргэж байна.

Улсын Их Хурлаар батлагдсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны үр дүн, цаг үеийн бусад асуудлаар нийтдээ 60 гаруй удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг хийж гүйцэтгэв.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааны мэдээ, мэдээлэлтэй холбоотой гэрэл зургийн санг баяжуулж, нийт 3029 зураг бүхий гэрэл зургийн 68 цомгийг “Нээлттэй парламент” цахим хуудаснаа байршуулав.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.

Хамгийн олон хандалттай “News.mn”, “Medee.mn”, “24tsag.mn”, “Time.mn” цахим сайт, өдөр тутмын зарим сонинтой гэрээ байгуулах замаар Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй түгээх арга хэмжээ авч байна. Түүнчлэн “Parliament.mn” нэрээр олон нийтийн Twitter, Facebook сүлжээгээр Улсын Их Хурлын цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж ирснээр Facebook сүлжээгээр мэдээлэл авдаг хэрэглэгчийн тоо 2200 болоод байгаа бол Twitter сүлжээгээр өдөр, цаг тутам мэдээлэл авагчдын тоо 9000-д хүрээд байна. Нээлттэй парламентын үйл ажиллагааг сурталчлах iOS болон андройд системийн 4 төрлийн аппликейшн программ бүтээж олон нийтэд хүргэлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаан,

хэлэлцүүлэг, семинар, өргөн барьсан хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүдийн цаг үеийн асуудлаар хийсэн хэвлэлийн бага хурал, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн хуралдааны талаарх дүрстэй мэдээ 432-ыг бэлтгэн www.parliament.mn, open.parliament.mn цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ “Парламент энэ долоо хоногт” нэвтрүүлгийн 38 дугаарыг бэлтгэж, МҮОНТелевиз, “Боловсрол”, “ETV”, “TV5”, “NTV”, “Ийгл”, “ETV”, “Парламентын суваг” телевизүүдээр дамжуулав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаан, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн мэдээлэл, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүдийн айлчлал, томилолтын тухай дүрс бичлэгийн мэдээллийн архив бүрдүүлсэн.

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор “Парламентын сэтгүүлчдийн гарын авлага”, “Үндсэн хууль-20” номыг бэлтгэж, Төрийн ордны тухай танилцуулгыг шинэчлэн монгол, англи хэлээр хэвлүүлэв.

Улсын Их Хурлын даргын 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн захирамжаар баталсан “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам”-ын дагуу Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаас эхлэн Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийн үнэмлэхийг өдөр тутмын 14 сонин, өргөн нэвтрүүлгийн 20 телевиз, кабелийн 8 телевиз, өргөн нэвтрүүлгийн болон FM радио, агентлагийн 5, өдөр тутмын бус 3 сонин, 1 сэтгүүл, мөн редакци бүхий олон хандалттай 15 цахим хуудасны 180 гаруй сурвалжлагч, зураглаач, гэрэл зурагчинд нэр зааж олгоод байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан парламентын сэтгүүлчдэд зориулан нэг өдрийн сургалт зохион байгуулав.

Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой 30-аад төрлийн 6000 гаруй ном, товхимлыг 21 аймаг, 9 дүүрэг дэх Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төвүүд болон бүх яам, агентлаг, нийтийн номын сан, хуулийн чиглэлээр сургалт эрхэлдэг их, дээд сургуулиудад түгээв.

Иргэд, олон нийтийг Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцуулах аяллыг 800 гаруй удаа зохион байгуулж, 30.000 гаруй иргэнд үйлчиллээ.

Иргэдийг хүлээн авах байранд 1334 иргэн УИХ-ын гишүүнд, 194 иргэн Тамгын газарт хандсаныг хүлээн авч уулзлаа. Иргэдээс гаргасан хүсэлтийн 85 хувь нь буюу 1353 нь хувийн хүсэлт буюу цагаатгал, тэтгэмж, сургалтын төлбөрийн талаар, 11.5 хувь буюу 175 нь Улсын Их Хурлаар хэлэлцэж буй асуудлын тухайд байв. Тамгын газар, Улсын Их Хурлаас томилогддог байгууллагуудтай холбоотой нийт 1488 гаруй санал ирснээс 1468 буюу 98.6 хувьд нь хариулт өгсөн байна.

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 120 гаруй хэвлэлийн хуудас бүхий 48 дугаарыг хугацаанд нь гаргаж, шуудангийн 5 компанитай байгуулсан гэрээний дагуу захиалагчдад хүргэв. Эмхэтгэлд Монгол Улсын хууль 171, Улсын Их Хурлын бусад шийдвэр 77, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 73, Засгийн газрын тогтоол 86, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 6 нийтлэгдсэнээс гадна зарим албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдээлэл, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлийг тус тус нийтэллээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны шийдвэр болон “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн Зөвлөлийн хуралдааны шийдвэрээр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж гаргаж, эмхэтгэлийг төрийн бүх шатны байгууллагад үнэ төлбөргүй тараадаг болов. 1991 оноос хойших “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн бүх дугаар, түүнчлэн “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 9 тусгай дугаарыг Улсын Их Хурлын цахим сүлжээнд байршуулж, iOS болон андройд системийн аппликейшн программыг ашиглан татаж унших боломжийг бүрдүүллээ.

Гурав. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар үзүүлсэн туслалцаа

Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын бүлгэм, Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2013 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөнд гадаадад 15, дотоодод 9 арга хэмжээ тусгагдаж батлагдсанаас төлөвлөгөөний дагуу гадаадад 13, дотоодод 6, төлөвлөгөөнөөс гадна гадаадад 2, дотоодод 9 буюу гадаад, дотоодод тус бүр 15 айлчлал, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Улсын Их Хурлын дарга, дэд дарга нарын урилгаар Монгол Улсад айлчилсан гадаадын парламентын төлөөлөгчдийн 15 айлчлал болон Улсын Их Хурлын дарга, дэд дарга нар, Улсын Их Хурлын гишүүдийн гадаадад хийсэн айлчлалыг цаг хугацаанд нь амжилттай зохион байгууллаа. Улсын Их Хурлын дарга З.Энхболд АНУ, Канад, БНТУ-д тус тус албан ёсны айлчлал хийж, БНХАУ-д зохион байгуулагдсан Азийн төлөөх Боа-гийн чуулга уулзалт, ШХУ-ын Женев хотноо зохион байгуулагдсан ОУПХ-ны 129 дүгээр Ассамблейд оролцжээ.

2013 онд Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлын гишүүд гадаад айлчлал, олон улсын хурал, семинар, танилцах аялал зэрэг нийт 256 /давхардсан тоогоор/ арга хэмжээнд оролцсон байна.

Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII бага хурал Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, тус бага хурлын хүрээнд Монгол, АНУ, Бутан, Гүрж, Индонези, Итали, Латви, Ливан, Литва, Мексик, Польш, Тайван, Финлянд зэрэг 15 улсын парламентаас 50 гаруй төлөөлөгч оролцож, парламентын ёс зүйг дээшлүүлэх, парламентын хяналт, авлигатай тэмцэх чадавхыг бэхжүүлэх болон хамтын ажиллагааны талаар өөр өөрийн орны туршлагыг солилцож,

хэлэлцүүлэг өрнүүлж, санал бодлоо солилцжээ.

“ Боловсролоор дамжуулан энх тайван, хөгжлийг урагшлуулахад эмэгтэй парламентчдын гүйцэтгэх үүрэг ” сэдэвт Зүүн хойд Азийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалтыг зохион байгуулж, чуулга уулзалтад ОХУ, БНХАУ, БНАСАУ, БНСУ-ын парламентын эмэгтэй гишүүд, НҮБ, түүний салбар байгууллагууд, Азийн сан зэрэг боловсрол, эмэгтэйчүүдийн оролцоо, хүний эрхийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын төлөөлөл оролцсон байна.

Тамгын газраас УИХ-ын гишүүдийг гадаад арга хэмжээнд оролцуулах, гадаад орны төлөөлөгчдийг хүлээн авах, журам, төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажилласан байна.

2013 онд Монгол Улсын Их Хурал, БНХАУ-ын БХАТИХ-ын хооронд хамтын ажиллагааны санамж бичиг, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Данийн Парламентын Тамгын газар хооронд хамтын ажиллагааны протокол байгуулсан нь талуудын хамтран ажиллах эрх зүйн орчинг бататгасан гэж үзэж байна.

Улсын Их Хурлын даргын 36, Улсын Их Хурлын дэд дарга нар болон Улсын Их Хурлын гишүүдийн 21, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 76 захидал, албан бичгийг боловсруулж орчуулан гадаадын парламент болон Олон улсын байгууллагуудад илгээж, гадаад айлчлал, арга хэмжээтэй холбогдуулан Монгол Улсаас гадаад орнуудад суугаа Элчин сайдын яамд, Улаанбаатар дахь гадаад улсын Элчин сайдын яамд болон олон улсын байгууллага, холбогдох газруудад 35 урилга, 142 факс, 140 ноот, 207 албан бичгийг илгээж, 800 гаруй хуудас материал орчуулсан байна.

Дөрөв. Санхүүгийн үйлчилгээ, технологийн шинэчлэл, техникийн туслалцаа

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:

Тамгын газар нь Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн төсөв, санхүү, аж ахуй, техник хэрэгсэл, материал хангамжийн үйлчилгээг үзүүлж ирлээ. Байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, аудитын дүгнэлт гаргуулан холбогдох байгууллагад хүргүүлэв.

Улсын Их Хурал, түүний бүтцийн нэгжүүдийн 2013 онд батлагдсан төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын тодотгосон төсвийн хуваарь хийж батлуулан төсвийн санхүүжилт, зарцуулалтын байдалд хяналт тавьж ажиллалаа.

Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангах, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх зардалд шаардагдах 2013 оны төсвийн тодотгосон төсвийг боловсруулж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлуулав.

2013 оны нийт төсөв 16,420.1 сая төгрөгөөр батлагдсанаас урсгал зардлын төсөвт 15,866.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 453.2 сая төгрөг, өөрийн төвлөрүүлэх орлого 100.0 сая төгрөгөөр тус тус батлагдсан.

Төсвийн урсгал зардалд 15,866.9 сая төгрөгийн санхүүжилт авахаас 14,654.5 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эцэст харилцах дансны үлдэгдэл 903.3 сая төгрөгийг улсын төсөвт шилжүүлэн 2064.9 сая төгрөгийн хэмнэлттэйгээр Улсын Их Хурлын гишүүдийн хэвийн үйл ажиллагаа, Улсын Их Хурлын чуулганы бэлтгэл ажлыг хангах, УИХ-ын гишүүдийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх болон мэдээлэл сурталчилгааны зардлын үр ашгийг боловсронгуй болгох, ажиллагсдын цалин хөлс, Улсын Их Хурлын гишүүдийн гадаад, дотоод томилолт, зочин төлөөлөгчид болон унаа, холбооны зардлыг шуурхай тооцож олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 453.2 сая төгрөгнөөс 370.5 сая төгрөгийн санхүүжилтээр худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг баримтлан худалдан авах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Хөрөнгө оруулалтын төсвийг 82.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах зориулалтаар техник хэрэгсэл, программ, эд хогшил худалдан авсан. Үүнд:

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Зарцуулсан зардал/төг/
1	iPAD-3	85 ширхэг	107.9 сая төгрөг
2	Компьютер	51 ширхэг	70.4 сая төгрөг
3	Сүлжээний халдлага илрүүлэх, хамгаалах программ	-	27.5 сая төгрөг
4	Сүлжээний хяналтын программ хангамж	-	5.0 сая төгрөг
5	Санхүүгийн программ хангамж	-	11.8 сая төгрөг
6	Сервер компьютер болон түүний дагалдах хэрэгсэл	1 ширхэг	25.0 сая төгрөг
7	УИХ-ын чуулганы танхимд камер, түүнд холбогдох төхөөрөмж	4 ширхэг	91.9 сая төгрөг
8	Тавилга, эд хогшил	-	31.0 сая төгрөг
	Бүгд		370.5 сая төгрөг

Улсын Их Хурлын 2013 оны урсгал төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг сар, улирал тутам байгууллага, нэгжээр гаргаж, санхүү эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй уялдуулан төсвийн алдагдлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар судалгаа дүгнэлт хийж, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл болон УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албанд танилцуулж, зохих арга хэмжээ аван хуваарьт зохицуулалт хийж зарцууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад журмын дагуу зохион байгуулж, 8 үнэлгээний хороогоор техникийн тодорхойлолтыг харгалзан, харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Принтерийн хор, цаас зэрэг урсгал зардлаас худалдан авах бараа ажил үйлчилгээнд 11 үнэлгээний хороо байгуулж, харьцуулалтын аргаар гүйцэтгэчийг сонгон шалгаруулж ажилласан нь төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах дэвшилттэй ажил болсон.

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинээр байгуулснаар 2013 онд дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Тухайлбал: 2013 оны жилийн эцсийн тооллогын үр дүнг авч хэлэлцэн элэгдлийн хугацаа дуусаж, анхны үнээ бүрэн нөхсөн 91 нэрийн 172508,9 мянган төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй боловч ашиглах боломжгүй болсон 12148,3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материалыг данснаас хасах асуудлыг Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлсэн байна.

2013 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор 5 нэр төрлийн 7,438,888.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг баркоджуулах ажлыг зохион байгуулснаар үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн дагуу 2012 оны батлагдсан төсвийн хэмнэлтийн урамшуулалд 206.6 сая төгрөг олгогдсоныг ажилтнуудын нийгмийн асуудлыг сайжруулахад зориулж 9 хүнд 103.7 сая төгрөг, 2013 оны ажлын үр дүн, ажилласан хугацааг харгалзан ажилтнуудын үр дүнгийн урамшуулалд 102.9 сая төгрөгийг олгосон байна.

Технологийн шинэчлэл, техник хангамжийн үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд технологийн шинэлэг шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллалаа.

Тамгын газрын албан хэрэгцээний компьютеруудын үйлдлийн систем, стандарт хэрэглээний программ хангамжуудыг үе шаттайгаар нээлттэй эхийн системд бүрэн шилжүүлж оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашигладаг болсон. Ашиглагдаж байгаа тусгай зориулалтын программ хангамжуудыг нээлттэй эхийн системд шилжүүлэх ажлыг эхлүүлэн Улсын Их Хурлын Номын сан, бичиг хэрэг, санхүүгийн программ хангамжийг шилжүүлээд байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг МҮОНТ-ийн 2-р суваг, ТМ телевиз, ДДишТВ, Сансар, Юнивишн кабелийн телевиз болон www.parliament.mn цахим хуудсаар шууд дамжуулдаг болсон.

Хөдөлгөөнт төхөөрөмжүүдэд зориулагдсан Төрийн мэдээллийн ТМ эмхэтгэл, цахим хуудасны ParliamentMN, хууль, эрх зүйн LawsMN программ хангамжуудыг шинээр бүтээж, хөдөлгөөнт оффисийн MyParliament системийг шинэчлэн сайжрууллаа. Эдгээр программуудыг давхардсан тоогоор 40.000 гаруй иргэн ашиглаж байна.

Интернетийн хурдыг нэмэгдүүлэн 50MB-100MB хурдаар үйлчилгээ авдаг болж, unlimited хэрэглэгчийн ангилалд багтсан. Мөн давхардсан тоогоор нийт 195 хэрэглэгчдэд сар бүрийн 1GB дата эрхтэй хөдөлгөөнт интернетийн үйлчилгээ үзүүлэн ажиллав.

Цахим хуудасны хандалтын тоо эрс нэмэгдэж, давхардсан тоогоор 3 сая орчим иргэн хууль тогтоох үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг онлайнаар авсан байна. Мэдээлэл дамжуулах тогтолцоог боловсронгуй болгон дотоод сүлжээний “Соёмбо” мессенжер программыг хөгжүүлж нэвтрүүлээ.

Компьютер, техник хангамжийн шинэчлэлт хийж, Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнуудад өндөр үзүүлэлт бүхий нийт 110 гаруй компьютер хуваарилан олгосон.

Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлага, шаардлагатай хэрэглэгчдийн нийт 89 өрөөнд Юнивишн IPTV-ийн холболт хийв.

Серверийн өрөөг шилжүүлж, шаардлагатай нэмэлт төхөөрөмжүүдээр тоногосноор стандартад нийцсэн цахим мэдээллийн төвтэй болсон. Компьютерийн сүлжээний орц, гарц дээр халдлага илрүүлэх төхөөрөмж суурилуулан мэдээллийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлсэн.

85 ширхэг iPad Retina төхөөрөмжийг нэмж ашиглаж эхэлснээр өдөр тутмын үйл ажиллагаанд нийт 190 хөдөлгөөнт төхөөрөмж ашиглагдах болсон.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд 4 ширхэг камер бүхий дижитал камерын системийг шинээр суурилуулж, системийн шинэчлэлт хийн тоон системд шилжих бэлтгэлийг хангав. Хуралдааны программ хангамжид 2 удаа нэмэлт өөрчлөлт хийж сайжруулсан.

2 аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдээллийн цахим самбар хүлээлгэн өгснөөр нийт 11 газарт хууль тогтоох үйл ажиллагааны мэдээллийг түгээх цахим самбарыг байрлуулаад байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих нь” болон “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслүүдийн хүрээнд Улсын Их Хурлын цахим хуудсыг хөгжүүлэх, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын интерактив цахим хуудсыг бүтээх ажлууд хийгдэж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хороод, ажлын хэсгийн хуралдаанд тараах материал болон хуулийн төсөл, өргөн баригдаж буй хууль, тогтоол, захирамж, гэрээ конвенц, Улсын Их Хурлын гишүүдэд ирсэн өргөдөл, санал гомдол болон Тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгцээнд 642646 ширхэг материалыг хувилан олшруулах үйлчилгээ үзүүлсэн байна.

Тав. Тамгын газрын хүний нөөцийн ашиглалт, ажилтнуудад үзүүлсэн дэмжлэг

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг тухай бүр хуралдуулж, цаг үеийн ажил, Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, ажилтнуудын нийгмийн асуудал, шагнал урамшуулал болон дотоод ажлын холбогдолтой асуудлуудыг авч хэлэлцэж, зохих шийдвэр гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирлээ.

Тайлант хугацаанд Тамгын газрын бүтэц, чиг үүрэг, орон тоог шинэчлэн баталсан бөгөөд бүтцийн өөрчлөлтөөр 227 нэгж орон тоотой байсныг 8 хэлтэс, 197 нэгж орон тоотой болгон өөрчилсөн. Одоогийн байдлаар 186 албан хаагч ажиллаж байна. Үүнээс:



- Нийт ажилтнуудын 36.3% нь 35-аас доош насны, 64.8% нь 45-аас доош насны ажилтнууд байна. Улсын байгууллагад 6-15 жил ажилласан ажилтнууд нь нийт ажилтнуудын 40.9%-ийг, 16-аас дээш жил ажилласан ажилтнууд 47.2%-ийг эзэлж байна.
- Төрийн захиргааны албан тушаалтан 163 буюу 84 %, төрийн үйлчилгээний албан тушаалтан 30 буюу 16 %,
- Мэргэжлийн хувьд эрх зүйч 80, эдийн засагч 40, бусад мэргэжлийн 73 ажилтан,
- Хүйсийн хувьд 193 ажилтны 108 нь буюу 56% нь эмэгтэй, 85 нь буюу 44% нь

эрэгтэй гэсэн үзүүлэлттэй байна.

Төрийн албаны зөвлөлийн 134 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн 148 ажилтантай үр дүнгийн гэрээ байгуулсан. Ажилтнуудын ажил, үүргийн хуваарьт өөрчлөлт оруулж, ажил үүргийн давхардлыг арилгах, ажлын цаг ашиглалт, ажлын уялдаа холбоог сайжруулахад анхааран ажиллаж байна. Тухайлбал: Хуулийн зөвлөхүүд Байнгын хорооны ажлын албанд харьяалагдан тухайн хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн төсөл дээр дагнаж мэргэшин ажиллаж байна. Хяналт, үнэлгээний хэлтсийг шинээр байгуулж, Төсвийн тухай хуульд заасны дагуу Дотоод аудиторыг томилон ажиллуулж, хяналтын тогтолцоог сайжруулахад анхааран ажиллалаа. Дотоод аудитор нь 2013 онд Улсын Их Хурлын төсвийн гүйцэтгэлийн 2013 оны 1, 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргалт, Улсын Их Хурлын төсвийн багцын 2013 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, ТЗҮАБ-аас автомашины үйлчилгээ авах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 96.3 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах 17 зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан тушаалтанд хүргүүлэн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Ажилтнуудын ажлын хариуцлага, ажлын чиг үүргийн давхардлыг хянах зорилгоор Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, ажлын байрны зураг авалтыг 2 удаа хийж, дүгнэлт гаргасан.

Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан хэрэг хөтлөх заавар, Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам, УИХ-ын Тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нийтлэг журам боловсруулж, УИХ-ын Тамгын газрын төсөв хуваарилах, үндсэн чиг үүргийг хангах, үр дүнг нь тооцох тогтмол үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан тус тус батлуулав. УИХ-ын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журам, Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон нийт 19 эрх зүйн актыг шинэчлэн боловсрууллаа.

Тайлант хугацаанд нийт 582 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн санд оруулав.

Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудаас холбогдох журмын болзол, нөхцөлийг хангасан Тамгын газрын 25 ажилтанд зэрэг дэв олгуулахаар судалгаа гаргаж, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад танилцуулаад байна.

Тус хугацаанд УИХ-ын гишүүн болон Тамгын газрын 17 /давхардсан тоогоор/ ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж, 3 ажилтанд сургалтын төлбөр, төрсөн нутагтаа болон сувилалд амарсан 8 хүнд зардал, 3 Улсын Их Хурлын гишүүнд эмчилгээний зардал, 11 ажилтанд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг

удаагийн тэтгэлэг олгосон.

Тайлант хугацаанд Тамгын газрын 3 ажилтан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 1 ажилтан Алтан гадас одонгоор, 14 ажилтан Хөдөлмөрийн хүндэт медалиар, 18 ажилтан салбарын тэргүүний ажилтан цол, тэмдгээр, 3 албан хаагч Жуух бичгээр тус тус шагнагдсан байна.

Ажилтнуудын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд Тамгын газрын 2013 оны сургалтын ерөнхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажилласан.

Тайлант хугацаанд 38 ажилтан Индонези, АНУ, БНХАУ, БНСУ, Сингапур зэрэг улсад 45 удаа танилцах дадлага, сургалт, айлчлалын бүрэлдэхүүнд болон туршлага солилцох үйл ажиллагаанд оролцож явсан байна.

Дотоодын их, дээд сургуулиудын бакалавр, магистрантур, докторантурын сургалтад нийт 35 ажилтан хамрагдан суралцаж байна.

Тамгын газрын ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор “Үр дүнд суурилсан хяналт үнэлгээний арга зүй”, “Мэдээлэл харилцааны салаа мөчрүүд болон Пи-Ар” зэрэг сэдвээр 7 удаа ажлын байран дахь сургалт, УИХ-ын гишүүний туслах, бие төлөөлөгч-туслахуудад зориулсан сургалтыг нийт 4 удаа зохион байгуулсан. Судлаачдыг чадавхжуулах зорилгоор “Судалгаа, мэдээлэл боловсруулах SPSS программ ашиглах нь” сэдэвт сургалт, Тамгын газрын удирдлагуудыг оролцуулан “Байгууллагын хүний нөөцийн удирдлага ба менежмент” сургалт, “Төрийн сайн засаглалыг хөгжүүлэх” нь сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Тамгын газрын мэдээллийн цагийг “Парламентын ажлын албадын туршлагаас”, “Нээлттэй эх”, “Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийн тухай”, “Амжилт ба амжилтад хүрэх арга зам” зэрэг сэдвээр 14 удаа зохион байгуулж, нийт ажилтан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслах, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд тус тус хамрагдсан.

Ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Англи хэлний сургалтын “Жэт” төвтэй гэрээ байгуулж, 14 ажилтныг сургалтад хамрууллаа.

УИХ-ын гишүүн болон ажилтнуудын бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшинг тогтоох сорилыг авч, Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны нийт 140 ажилтныг хамруулсан.

Бялдаржуулах танхимаар Улсын Их Хурлын гишүүн, тэдгээрийн зөвлөх, туслах, бие төлөөлөгч туслах, Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд буюу давхардсан тоогоор нийт 148 албан хаагч үйлчлүүлсэн байна. Бялдаржуулах танхимд дэлгэцийн гольф тоглох боломжийг бүрдүүлэн тохижуулалт, засварын ажлыг гүйцэтгэлээ.

Зургаа. 2013 оны үйл ажиллагааны товч дүгнэлт

Улсын Их Хурлын Тамгын газар 2013 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, эрхлэх ажлын хүрээнд ажил, үйлчилгээг зохих шаардлагын хэмжээнд хийж гүйцэтгэлээ.

Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, сайжруулах арга хэмжээний хүрээнд өмнө нь нийт 227 нэгж орон тоотой байсныг 197 болгон цөөрүүлж, төсөв хэмнэсэн, цомхон чадварлаг бүтэцтэйгээр ажиллаж байна.

Чуулганы хуралдааны бэлтгэл хангах, хуулийн төслийг эх барьж ажиллах, төсөлтэй холбоотой мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх талаар, Тамгын газрын ажилтнуудын ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах зорилгоор Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах журам”, мөн “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах үе шатанд холбогдох албан тушаалтны хариуцан гүйцэтгэх ажил үүргийн хуваарь”-ийг батлан мөрдөж байна.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд анх удаа бие даан шинжилгээ хийж, өөрчлөлтийн саналууд гарган хэлэлцүүлсэн.

Оюуны өмчийн зөрчилгүй программ хангамжийг ашиглаж эхэлснээрээ УИХ-ын Тамгын газар “Нээлттэй эх”-ийн систем рүү шилжсэн анхны төрийн байгууллага болсон бөгөөд улсын төсөвт 1 тэрбум гаруй төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих нь” болон “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд Удирдлагын академи, Хүний эрхийн комисс, Авлигатай тэмцэх газар, МУИС-тай хамтран сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, Улаанбаатар хотын 3 дүүрэг, 5 аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулаад байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нийтлэг журмыг батлуулж ажилласнаар Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн, хөрөнгө оруулалтын зардлыг 82.7 сая төгрөгөөр, батлагдсан төсвийн зарцуулалтыг 2.1 тэрбум төгрөгөөр хэмнэсэн.

Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай, үнэн зөв мэдээллээр шуурхай хангах, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад мэдээллийн хүртээмжтэй, ил тод байдал нэн чухал гэж үзсэний үндсэн дээр www.parliament.mn, www.legalinfo.mn цахим хуудсанд хууль, тогтоол, дүрэм, журмыг тухай бүр шинэчлэн оруулах, “Төрийн

мэдээлэл” сэтгүүлийг эмхэтгэн гаргаж, цахим хэлбэрээр түгээх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон нийтийн цахим сүлжээг идэвхтэй ашиглах, Номын сан болон УИХ-ын үйл ажиллагааны мэдээллүүдийг цахим хэлбэрт оруулан, хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Тамгын газрын 2012 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд ажлыг эрчимжүүлэх зорилгоор өгөгдсөн 9 үүрэг, даалгаврын дагуу холбогдох хэлтэс, албадад үүрэг өгч, хэрэгжилтийг хангуулж ажилласан.

Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлж байгаа судалгааны захиалгын агуулга тодорхой бус, өргөн цар хүрээг хамарсан, хугацаа давчуу байдгаас судалгааны ажилд тодорхой хүндрэл учруулж байгаа тул цаашид Тамгын газраас зөвхөн Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудалд хамаарах судалгаа, мэдээллээр хангах үүднээс Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн санаачлан боловсруулж байгаа хууль, тогтоолын төсөлтэй холбоотой судалгааны ажлыг батлагдсан төсвийнхөө хүрээнд бусад байгууллага, судлаачдаар гүйцэтгүүлэх нь зүйтэйг тэмдэглэж байна.

Тамгын газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод аудитор, Хяналт үнэлгээний хэлтсийн ажилтнуудыг оролцуулан үнэлгээ хийлгэсэн бөгөөд үнэлгээний багаас дараах зөвлөмжийг өгсөн болно. Үүнд:

Ажилтнуудын мэргэшил, үр чадварыг сайжруулах үүднээс:

-Хуулийн төсөл боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хянах, хуулийн төсөлд эдийн засгийн үр ашгийн тооцоолол хийх талаар мэргэжилтнүүд урьж, онол, практикийн сургалт явуулах;

-Хуулийн төслийн эхийг барин, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан Тамгын газрын ажилтнуудад тодорхой урамшуулал олгож байх хөшүүргийн механизм бүрдүүлэх;

-Ажилтнуудыг гадаадад болон онлайн хэлбэрээр богино болон урт хугацааны сургалтад сургах;

-Ажилтнуудыг мэргэшүүлэх үүднээс, судалгаа шинжилгээний ажил хийлгэх, гаргасан бүтээлээр тооцох урамшууллын тогтолцоог бий болгох;

Мэдээлэл солилцоо, нэгж хэсгүүдийн хоорондын харилцан уялдаа:

-Хэлтэс, нэгж бүр хийж байгаа болон цаашид хийх ажлуудаа тогтмол хугацаанд бусад нэгжийн ажилтнуудад тайлагнах, хамтын ажиллагааны боломжуудыг эрэлхийлж байх.

Дотоод хяналт, төсөв санхүүгийн талаар:

-Хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс нийцлийн аудиторын орон тоог бий болгон нэгжийн бүтцээр ажиллуулах;

-Гадаад томилолттой холбоотой зардал /зочны зардал, нислэгийн тийз, бэлэг, дурсгал/-ыг Тамгын газрын чиг үүрэгт заагдсанаар үндсэн нэгжээр нь хэрэгжүүлэх;

- Ажиллагсадын ажиллах нөхцөл, өрөө тасалгаа, бичиг хэрэг, техник хэрэгслэлд норм, норматив тогтоон мөрдүүлж, цалин урамшуулал олгож буй өнөөгийн сүлжээ/Засгийн газрын 2012 оны 78 тоот тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээ/-г эргэж харах;

-Тамгын газрын хэлтэс, албадын ажлын чиг үүргийг шинэчлэн баталж, Дотоод аудитор, Хяналт үнэлгээний хэлтэс, Экспертийн алба зэрэг шинэ нэгжүүд бий болсонтой уялдуулан Тамгын газрын дүрмийг шинэчлэх нь зүйтэй байна.

Дээрх зөвлөмжийг 2014 оны зорилтод тусган ажиллахаар төлөвлөж байна.

Долоо. 2014 оны үйл ажиллагааны зорилт

Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд онолын үндэслэлтэй, хууль тогтоомжид нийцсэн, бодит судалгаанд үндэслэсэн, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд хийж байгаа ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд “Ухаалаг төр”-ийн зарчмыг баримталж, дараах ажилд анхаарал хандуулан ажиллах зорилт тавьж байна. Үүнд:

-Улсын Их Хурал, Байнгын дэд, түр хороо, ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдэд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн бүрдлийг хянах, төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргах үндсэн чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, ажилтан бүр эрхэлсэн ажилдаа бүтээлч, хариуцлагатай хандаж, Улсын Их Хурлаас баталж байгаа хууль тогтоомж, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, хууль зүйн техник, хэл, найруулгын алдаагүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах;

-Тамгын газрын нийт ажилтны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж чадавхжуулах зорилгоор “Эрх зүй”-н сургалтыг жилийн турш зохион байгуулах;

-Тамгын газарт мөрдөгдөж буй дотоод журам, заавар зэрэг бүх баримт бичигт мониторинг хийх;

-Тамгын газрын ажилтнуудын ажлын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, цомхон, чадварлаг бүтэц бүрдүүлэх;

-Санхүүгийн гүйлгээнд шилэн дансны тогтолцоог нэвтрүүлэх;

-Албан хэрэгцээнд ашиглаж байгаа программ хангамж, системүүдийг үе шаттайгаар “Нээлттэй эх рүү” бүрэн шилжүүлэх;

-Хуулийн хувийн хэргийн цахим системийг он дарааллын үе шаттайгаар нэвтрүүлэх;

-Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог болон ажлаа тайлагнадаг байгууллагуудын мэдээлэл солилцооны нэгдсэн систем /программ хангамж/-ийг нэвтрүүлэх;

-Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим системийг БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/-тай хамтран иж бүрэн шинэчлэх;

-Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны танхимуудын цэнэгжилтийг бууруулах шийдэл боловсруулж нэвтрүүлэх;

-Улсын Их Хурлын үйл ажиллагааг МҮОНР-ийн III суваг, зарим ФМ радиогоор нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

-УИХ-ын үйл ажиллагааны 7 хоногийн тойм мэдээллийг хураангуйлан англи хэлээр бэлтгэн телевиз, www.parliament.mn, www.youtube.com цахим сүлжээгээр нэвтрүүлэх ажлыг эхлүүлж тогтмолжуулах;

-Улсын Их Хурлын гишүүний иргэд, сонгогчидтой онлайн ярилцлага хийх нөхцөлийг бүрдүүлэх;

-”Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь”, Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь “ төслүүдийг Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;

-Захиалгат судалгааг Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж буй хууль тогтоомжийн чанар, үндэслэлийг сайжруулахад чиглүүлэн, захиалагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн тоо, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх;

-Улсын Их Хурлын Номын сангийн үйлчилгээг шинэлэг, уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, уян хатан, боловсронгуй болгох, цахим мэдээллийн санг сайжруулан, уншигчдад зайнаас үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлэх;

-Архивын баримтыг заавар, журмын дагуу бүрдүүлж, байгууллага, иргэдэд архивын лавлагаа, мэдээллээр шуурхай үйлчилж, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнуудад архивын баримт олгож, архивын баримтын ашиглалтыг сайжруулж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх.

Улсын Их Хурлын Тамгын газар